

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/02/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудитын хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
Байгууллагын үйл ажилагаа	10
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.2.1 Залруулсан алдаа	13
4.2 .2 Төлбөрийн акт.....	13
4.2.3 Албан шаардлага	13
4.2.4 Зөвлөмж	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠋᠋᠋᠋ 03. 23 № 321
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭНТИЙ-УС ХХК-НИЙ ЗАХИРАЛ
Г.БАТГЭРЭЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР



02302

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,612,359.01	63,366,826.52
2	Дансны авлага	285,739,130.21	295,959,602.00
3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	124,280.00
4	Бусад авлага	178,612,370.47	250,485,254.72
5	Бараа материал	302,554,286.27	388,329,215.79
6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	49,566,203.44
7	Эргэлтийн хөрөнгийн дүн	778,518,145.96	1,047,831,382.47
8	Үндсэн хөрөнгө	12,152,953,262.31	21,907,481,764.32
9	Биет бус хөрөнгө	5,357,912,000.00	5,357,912,000.00
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,510,865,262.31	27,265,393,764.32
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,289,383,408.27	28,313,225,146.79
12	Дансны өглөг	371,822,993.00	554,935,824.95
13	Татварын өр	133,275,051.74	127,907,573.51
14	НДШ - ийн өглөг	153,314,247.89	39,870,796.62
15	Богино хугацаат зээл	113,500,006.00	46,833,344.00
16	Урьдчилж орсон орлого	5,498,780,312.14	7,064,632,476.42
17	Бусад богино хугацаат өр төлбөр	39,282,791.95	45,464,621.35
18	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,309,975,402.72	7,879,644,636.85
19	Урт хугацаат зээл	2,036,013,857.57	2,036,013,857.57
20	Бусад урт хугацаат өр төлбөр	4,210,425.73	8,581,717,754.89
21	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,040,224,283.30	10,617,731,612.46
22	Өр төлбөрийн нийт дүн	8,350,199,686.02	18,497,376,249.31
23	Өмч: - төрийн	8,644,662,384.67	8,644,662,384.67
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,675,409,524.20	1,675,409,524.20
25	Эздийн өмчийн бусад хэсэг	364,616,130.00	364,616,130.00
26	Хуримтлагдсан ашиг	-745,504,316.62	-868,839,141.39
27	Тайлангийн үеийн ашиг	0.00	-123,334,824.77
28	Өмнөх үеийн ашиг	-745,504,316.62	-745,504,316.62
29	Эздийн өмчийн дүн	9,939,183,722.25	9,815,848,897.48
30	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,289,383,408.27	28,313,225,146.79

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаа	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	4,020,641,436.38	4,355,398,723.96
02	Борлуулалтын өртөг	4,209,448,380.61	4,475,547,372.13
03	Нийт ашиг(алдагдал)	-188,806,944.23	-120,148,648.17
08	Бусад орлого	269,600,000.00	494,643,322.28
08.1	Орлогын дүн	269,600,000.00	494,643,322.28
09	Борлуулалт, маркетингийн зардал	21,799,925.01	10,832,413.66
10	Ерөнхий ба удирдлагын зардал	338,090,406.58	486,997,085.22
12.1	Зардлын дүн	359,890,331.59	497,829,498.88
17	Бусад ашиг (алдагдал)	279,592,685.27	-3,186,176.60
17.1	Олз, гарзын дүн	279,592,685.27	-3,186,176.60
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	495,409.45	-123,334,824.77
19	Орлогын татварын зардал	49,540.95	2,628,776.76
20	Татварын дараах ашиг (алдагдал)	445,868.50	-123,334,824.77
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	445,868.50	-123,334,824.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,613,464,245.50	5,440,234,777.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,342,168,992.85	4,868,960,208.19
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	269,600,000.00	386,600,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,695,252.65	184,674,569.25
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,605,369,359.81	5,193,643,614.30
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,233,307,761.37	1,203,884,654.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	270,700,000.00	514,786,834.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,314,961,271.00	1,260,452,014.94
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	505,357,701.99	532,511,838.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	670,749,648.44	735,847,412.26
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	21,983,151.48	12,008,209.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	276,654,306.91	355,017,167.34
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	4,844,172.00	4,624,235.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	306,811,346.62	574,511,248.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,094,885.69	246,591,163.14
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	58,267,148.91	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	42,272,322.28	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	15,994,826.63	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	57,114,750.00	125,270,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	57,114,750.00	125,270,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгө	1,152,398.91	-125,270,800.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,666,662.00	69,565,895.63
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	66,666,662.00	69,565,895.63
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-66,666,662.00	-69,565,895.63
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-57,419,377.40	51,754,467.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	69,031,736.41	11,612,359.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,612,359.01	63,366,826.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,320,071,908.87	562,882,380.00	-756,959,271.82	10,125,995,017.05
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны за	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	11,009,086.70	11,009,086.70
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	445,868.50	445,868.50
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	-198,266,250.00	0.00	-198,266,250.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
09	2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,320,071,908.87	364,616,130.00	-745,504,316.62	9,939,183,722.25
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны за	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-123,334,824.77	-123,334,824.77
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2021 оын 12 сарын 31-р үлдэгдэл	10,320,071,908.87	364,616,130.00	-868,839,141.39	9,815,848,897.48

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Ариунаа, Г.Энх-Амгалан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий-Ус ХХК нь 2021 оны санхүүгийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь Хэнтий нутгийн хэрэглэгч бүрийг илүү жаргалтай, тав тухтай амьдрахад хувь нэмрээ оруулж, өдөр бүр хүртээмжтэй, шуурхай сэтгэл татам үйлчилгээг үзүүлж, хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг 98% -д хүргэж үйлчилнэ.

Хэнтий-Ус ХХК нь барилга угсралт, дулаан үйлдвэрлэл, усан хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 4,569.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 45.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75% буюу 34.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Хэнтий-Ус ХХК-ний зорилго нь нийтийн аж ахуйн үйлчилгээг хүн бүрд хүртээмжтэй хүргэн ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг ус хангамж, ариутгал татуурга, дулаан хангамж, нийтийн халуун ус, барилга засвар үйлчилгээ түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” статустай байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хэнтий-Ус ХХК нь аймгийн ИТХ-ын 2001 оны 59 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4-т “Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.” гэсэн заалттай нийцэж байна.

Хэнтий-Ус ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.4 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын

жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоогоогүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хэнтий-Ус ХХК-ний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,612.3	63,366.8	(51,754.5)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-
Авлага	464,351.5	546,569.1	(82,217.6)
Урьдчилж төлсөн зардал	-	49,566.2	(49,566.2)
Бараа материал	302,554.3	388,329.2	(85,774.9)
Үндсэн хөрөнгө	12,152,953.3	21,907,481.8	(9,754,528.5)
Биет бус хөрөнгө	5,357,912.0	5,357,912.0	-
Нийт хөрөнгө	18,289,383.4	28,313,225.1	(10,023,841.7)
Өр төлбөрийн дүн	658,412.3	722,714.2	(64,301.9)
Богино хугацаат өглөг	152,782.8	92,297.9	60,484.9
Урьдчилж орсон орлого	5,498,780.3	7,064,632.5	(1,565,852.2)
Урт хугацаат өглөг	2,040,224.3	10,617,731.6	(8,577,507.3)
Эздийн өмч	9,939,183.7	9,815,848.9	123,334.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,289,383.4	28,313,225.1	(10,023,841.7)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 2.2 сая төгрөг касс дахь бэлэн мөнгө, 61.2 сая төгрөг банк дахь мөнгөний үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд төрийн банкны харилцах дансанд байгаа 9.1 сая төгрөг, хаан банкны 2 харилцах дансанд байгаа 28.3 сая төгрөг, хас банкны харилцах дансанд байгаа 23.8 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд төрөөс хариуцан төлөх аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн халаалт, цэвэр бохир усны авлага 294.0 сая төгрөг, ХААН банкны барьцаанд байгаа 73.5 сая төгрөг, цэвэр усны шугамын засварын 23.5 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын авлага 57.2 сая төгрөг эзэлж байна.

Авлагын үлдэгдлийн 546.1 сая төгрөг хугацаандаа байгаа авлага байна.

Тайлант онд байгууллагын гадна засварын ажлын төлбөрт 49.6 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлснээр нэмэгдсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 388.3 сая төгрөг болж 85.8 сая төгрөгөөр өссөн нь тухий эд материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө тайлант онд худалдан авалтаар 122.9 сая төгрөг, аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 6,753.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Барилга байгууламж дансанд цэвэр усны шинэчлэл, усан сангийн шугам, 60 айлын инженерийн шугам сүлжээний ажлын 1,704.8 сая төгрөг, цэвэрлэх байгууламжийн барилга 4,931.5 сая төгрөг, гүний худаг 20.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмж дансанд насос 3.2 сая төгрөг, тээврийн хэрэгсэл дансанд универсал трактор 93.4 сая төгрөгөөр нийт 6,753.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд дансны өглөг 554.9 сая төгрөг, татварын өр 127.9 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 39.9 сая төгрөг, богино хугацаат зээл 46.8 сая төгрөг байна. Богино хугацаат зээл нь Хас банкнаас 2019 онд 36 сарын хугацаагаар үндсэн хөрөнгө худалдан авах зориулалтаар авсан зээл бөгөөд зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж, 2022 оны 5 сард дуусна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Азийн хөгжлийн банкнаас 2003 онд “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН-1907-ийн хүрээнд зүүн болон төвийн бүсийн аймгийн “Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээний менежментийн чадавхийг дээшлүүлэх”-д зориулан авсан зээлийн 2,040.2 сая төгрөг, 2019 онд “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт”-ээр авсан 8,577.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал гэж ангилсан байна. Зардлыг өмнөх онтой харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 266.1 төгрөгөөр нэмэгдсэн нь түүхий эд материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цэвэр, бохир ус, дулааны үйлдвэрлэлийн үе шатанд зарцуулсан цалин, шимтгэл, нүүрс, шатахуун, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалын зардлуудыг хамруулсан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хэнтий-Ус ХХК байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хэнтий-Ус ХХК-ний Удирдах зөвлөлийн 2020 оны .. дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ын 2021 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө, их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөө, орон тоо, цалингийн санг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,859.0

сая төгрөгөөр, нийт зардлыг 4,841.1 сая төгрөгөөр, 17.9 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хөрөнгө зарцуулахаар төлөвлөөгүй байна.

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны дугаар тушаалаар Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, борлуулалтын орлогыг 4,859.0 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 4,850.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,973.3 сая төгрөгийн зардал гарган, 123.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,850.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 9.0 сая төгрөг буюу хувиар тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,973.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 132.2 сая төгрөг буюу 2.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна..

Тайлант онд цэвэр алдагдал 123.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 107.4 сая төгрөгөөр илүү байгаа нь бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд 5,240.3 сая төгрөгийн худалдан авалтын тендерийн мэдээлэл, өрийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын тооцоо, анхан шатны баримтын бүрдүүлэлт, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг үндсэн хөрөнгө тус бүрээр авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 371.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 333.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 20.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 17.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Орлогыг 10.1 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулж, үйл ажиллагааны бус бусад орлогод бүртгэж залруулсан.

Үйл ажиллагааны бус бусад орлогын дансанд 303.6 сая төгрөгийн элэгдлийн зардал бүртгэснийг залруулсан.

Малын нас дэвшилтийн орлогын 12.5 сая төгрөг, зарлагын 7.4 сая төгрөгийг өглөгийн дансанд бүртгэснийг туслах аж ахуйн орлого, зардалд залруулсан.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.2.3 Албан шаардлага

Бараа материалын үлдэгдэл 7.3 сая төгрөгөөр зөрүүтэй, нярвын тайлан байхгүй.

Ажилтнуудад үндэслэлгүй 13.1 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон

4.2.4 Зөвлөмж

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан санхүүгийн төлөвлөгөөний орлогыг дутуу төвлөрүүлж, зарлагыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, алдагдалтай ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасныг мөрдөн батлагдсан төлөвлөгөөний орлого, зарлагын биелэлтийг хангаж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий-Ус ХХК	6	371.9	3	333.6			2	20.4	1	17.9
Дүн		6	371.9	3	333.6			2	20.4	1	17.9



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 198/А 2370448
ХТА 2022/02/НА СТА ТНЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад үндэслэлгүй 13,110.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэнтий-Ус ХХК-ний захирал Г.Батгэрэл, нягтлан бодогч Г.Энхсаруул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 197/А2370448
ХТА 2022/02/НА СТА ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ний 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдэл 7,319.3 сая төгрөгөөр зөрүүтэй, эд хариуцагчийн тайланг хэвлэж хавсаргаагүй байсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах," гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэнтий-Ус ХХК-ний захирал Г.Батгэрэл, нягтлан бодогч Г.Энхсаруул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

